

**ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
2021 он**

АГУУЛГА:

Аудитын нэр, код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилго.....	3
Аудитын хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	4
Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ	6
Аудитын арга зүй	6
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	6
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	8
Аудитын хийх хугацаа	7
Аудитын хөтөлбөр	7
Аудитад шаардагдах нөөц	8

ХАВСРАЛТУУД:

Хавсралт 1.	Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ
Хавсралт 2.	Асуудлын шинжилгээ
Хавсралт 3.	Аудитын загварын матриц
Хавсралт 4.	Аудитын хөтөлбөр
Хавсралт 5.	Шинжээчийн ажлын даалгавар
Хавсралт 6.	Аудитын үр өгөөжийн төлөвлөлт

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Д.ЗАНДАНБАТ
АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын сэдэв

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө

2. Аудитын код:

АГГ-2021/14-ШТА-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийнэ.

4. Аудитын зорилго

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэнэ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх;
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөлт буурч, эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх.

5. Аудитын хамрах хүрээ

Аудитад Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаарх төрийн зохицуулалт, "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан тайлан, хяналт-үнэлгээний тайлан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжүүд, түүний хэрэгжилтийн тайлан, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн болон өнчин эмийн жагсаалтыг баталсан шийдвэр, үндэслэл, дээрх жагсаалтад орсон эмийн үнийн дээд хязгаарыг баталсан шийдвэр болон бусад холбогдох баримт материалыг хамруулна.

Аудитаар Эрүүл мэндийн яам, Хүний эмийн зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, орон нутгийн засаг, захиргааны нэгж болон бусад холбогдох байгууллагын 2018-2020 оны аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулна.

6. Үндсэн мэдээлэл

Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого” батлагджээ. Уг бодлогын баримт бичгийн зорилгыг “Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай, сонголт хийх боломж бүхий эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 425 дугаар тушаалаар “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 2765 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 2343 буюу 84.7 хувийг эмийн сан, 384 буюу 13.9 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, 38 буюу 1.4 хувийг эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр тус тус эзэлж байна.

Эмийн сан эрхлэх тусгай зөвшөөрөл 2020 онд шинээр 79-ийг олгосноос нийслэлд 44, орон нутагт 35 байна. Мөн нийслэлд 350, орон нутагт 79 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг сунгасан байна.

Нийт эмийн сангийн 1343 нь Улаанбаатарт, 1000 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаагаас 234 буюу 10.0 хувь нь I зэрэглэлийн, 1798 буюу 76.7 хувь нь II зэрэглэлийн, 311 буюу 13.3 хувь нь эргэлтийн эмийн сан байна.

Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 384 байгууллага нь давхардсан тоогоор 258 эм, 296 эмнэлгийн хэрэгсэл, 184 эмнэлгийн тоног төхөөрөмж, 102 биологийн идэвхт бүтээгдэхүүн, 78 лабораторийн оношлуур, урвалж хэрэгсэл, 45 протез, 12 ариутгал, халдваргүйтгэлийн бодис ханган нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Дотоодын эм, эмнэлгийн хэрэгслийн тусгай зөвшөөрөлтэй 38 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас эмийн 24, эмнэлгийн хэрэгслийн 6, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын 4, биологийн идэвхт бүтээгдэхүүний 10, протезын 3 үйлдвэр байна.

Үндэсний эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрүүд 2020 онд нийт 63.3 тэрбум төгрөгийн 273 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 61.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийснээс 41.1 тэрбум төгрөгийн 220 нэрийн эм үйлдвэрлэж, 40.5 тэрбум төгрөгийн борлуулалт, 22.9 тэрбум төгрөгийн 15 нэрийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж, 22.2 тэрбум төгрөгийн борлуулалт, 1.2 тэрбум төгрөгийн 18 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1.2 тэрбум төгрөгийн борлуулалт, 7.1 тэрбум төгрөгийн 20 нэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 6.3 тэрбум төгрөгийн борлуулалт тус тус хийсэн байна.

Сүүлийн 5 жилийн эм, эмнэлгийн хэрэгсэл импортолсон байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, оношлуурын импорт, борлуулалт, тэрбум төгрөг

Он	Эм		Эмнэлгийн хэрэгсэл		Урвалж бодис		Оношлуур	
	Импорт	Борлуулалт	Импорт	Борлуулалт	Импорт	Борлуулалт	Импорт	Борлуулалт
2016	214.6	183.0	19.3	18.2	11.5	10.9	7.8	7.3
2017	234.1	221.2	22.2	21.0	10.8	10.2	11.5	11.0
2018	362.5	299.0	27.1	24.6	14.6	13.9	12.4	10.6
2019	310.1	308.4	23.1	22.7	9.3	9.6	13.8	13.1
2020	321.8	299.5	232.2	147.6	12.4	11.7	19.4	17.7

Сүүлийн 5 жилийн дүнгээс харахад 2020 онд эм, эмнэлгийн хэрэгслийн импорт 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2.3 дахин, борлуулалт нь 7.6 дахин нэмэгдсэн байна.

Манай улсад 2020 онд нийт бүртгэлтэй 4511 эм байгаагаас үндэсний үйлдвэрүүд 220 нэрийн уламжлалт болон бусад эм үйлдвэрлэсэн байна. Нийт бүртгэлтэй эмийн 27.8 хувь нь жоргүй олгох, 70.4 хувь нь жороор олгох, 1.8 хувь нь эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эм байна.

7. Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ

Аудитын урьдчилсан судалгааны явцад судалсан баримт материал, хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд хийх аудитын 28 эрсдэлийг тодорхойлж, ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. (Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээг хавсралт 1-д үзүүлэв)

8. Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээг хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулж гүйцэтгэнэ.

Аудит хийх Асуудлын шинжилгээг хавсралт 2-т, Аудитын арга зүйг хавсралт 3-т тус тус үзүүлэв.

Аудитын урьдчилсан судалгааны явцад хөндлөнгийн шинжээч, зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээг тодорхойлон, шинжээчийн ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөний хавсралт 5-д хавсаргав.

Аудитын явцад аудитын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Гүйцэтгэлийн аудитын суурь зарчим /арвилан хэмнэлт, үр өгөөж, үр нөлөө/
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Гаалийн тухай хууль;
- Зар сурталчилгааны тухай;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай;
- Үндэсний аюулгүй байдлын тухай;
- “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого” (Улсын Их Хурлын 2014 оны 54 дүгээр тогтоол);
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол);
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого; (Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол);
- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай; (Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоол)
- Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам (Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоол);
- Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай (Засгийн газрын 2011 оны 73 дугаар тогтоол);
- Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Төлөвлөгөө батлах тухай” 425 дугаар тушаалаар баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- Бусад холбогдох журам, аргачлал, стандартууд.

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

- Аудитын явцыг хянан удирдах ажилтан: Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны хяналтыг хэрэгжүүлнэ.
- Аудит хийх аудиторууд: Аудитыг ахлах аудитор Б.Батдэлгэр, аудитор Б.Булган, Э.Уянга, М.Өлзиймягмар нар гүйцэтгэнэ.
- Аудитад оролцох гаднын шинжээч, зөвлөх: Худалдан авах ажиллагааны үр дүнгээр тодорно.

11. Аудит хийх хугацаа

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулна. Аудитын тайланг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дуусгана.

12. Аудитын хөтөлбөр

Аудитын талбарын ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл гүйцэтгэн, аудитын тайланд холбогдох үе шатны хяналт хийлгэн, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. (Аудитын хөтөлбөрийг хавсралт 4-өөс үзнэ үү.)

ХЯНАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ

Боловсруулсан:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЭНХБОЛД

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.САРУУЛ

АХЛАХ АУДИТОР

Б.БАТДЭЛГЭР

АУДИТОР

Б.БУЛГАН

Э.УЯНГА

М.ӨЛЗИЙМЯГМАР